

гүйцэтгэв. Шинжилгээг БНСУ-ын Standart Diagnostics, INC-д үйлдвэрлэсэн өвөрмөц болон мэдрэг чанар 99%-тай SD Bioline хурдавчилсан оношлуураар хийж гүйцэтгэв. Судалгааг 2010 оны 4 дүгээр сараас 8 дугаар сарын 1-ийг хүртэл 4 сарын хугацаанд Улаанбаатар хотын 9 дүүрэгт амьдарч буй 16-50 насны эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 180 эрчүүдийг хамруулан хийв.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 181 эрчүүдийн 14%(25)-д гепатитын В вирусийн гадаргуугийн HBsAg эерэг, 15%(27)-HCV эерэг, 13,3% (24) ХДХВ-ийн халдвар, 14%(25)-д нь тэмбүүгийн халдвар тус тус илэрсэн. ХДХВ-ийн халдвар илэрсэн эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 3% нь шинэ халдвар, 10% нь өмнө нь ХДХВ-ийн халдвар оношлогдож одоо хяналтанд байгаа хүмүүс хамрагдсан. Энэхүү судалгааны ажлын явцад ХДХВ-ийн халдварын 6 шинэ тохиолдлыг эрт илрүүлэн хяналтанд авсан нь хувь хүнд төдийгүй нийгэм, хамт олны эрүүл мэндэд ихээхэн ач холбогдолтой, цаг үеэ олсон судалгаа болохыг харуулж байна. ХДХВ-ийн халдвар илэрсэн ЭБЭ нь 20-45 насны залуучууд байгаа бөгөөд шинээр ХДХВ-ийн халдвартай болох нь оношлогдсон 6 хүн нь 20-42 насны эрчүүд байна. Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 181 эрчүүдийн 14%(25)-д гепатитын В вирусийн гадаргуугийн HBsAg эерэг, 15%(27)-HCV эерэг, 8%-гепатитын В, С вирусийн хавсарсан халдвар илэрсэн. Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 181 эрчүүдийн 14%(25)-д тэмбүүгийн халдвар илэрсэн байна. Үүний 4%(8) шинэ, 10%(17) нь өмнө нь тэмбүүгийн халдвар авсан нь оношлогдож хяналтанд байгаа хүмүүс хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан эрчүүдийн 8%-д ХДХВ, тэмбүүгийн хавсарсан халдвар оношлогдсон байна.

Дүгнэлт

1. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 13,3%-д ХДХВ-ийн халдвар илэрч үүний 3% нь шинэ халдвар байгаа нь ЭБЭ олон нийтийн дунд ХДХВ-ийн халдвар үргэлжлэн тархсаар байгааг харуулж байна.

2. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 14%-д гепатитын В вирусийн гадаргуугийн HBsAg эерэг, 15%-д HCV эерэг, 8%- д нь гепатитын В, С вирусийн хавсарсан халдвар илэрсэн нь гепатитын вирусийн халдварлалт өндөр байгааг нотолж байна.

3. Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 14%-д тэмбүүгийн халдвар илэрч, 8%-д ХДХВ, тэмбүүгийн хавсарсан халдвар оношлогдсон нь ЭБЭ олон нийтийн дунд БЗДХ өндөр байгааг харуулах үзүүлэлт юм.

Монгол хүүхдүүдийн дундах Кавасакийн өвчний эргэмж судалгаа

Д.Байгалмаа¹, Б.Отгончимэг², Д.Даваалхам³

¹ Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв,

² Эх Нялхасын Эрдэм Шинжилгээний Төв

³ Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуул

Кавасакийн өвчнийг (КӨ) анх 1967 онд Японы хүүхдийн эмч, эрдэмтэн Томисаку Кавасаки илрүүлсэн бөгөөд эдүгээ дэлхий даяар уг өвчний шинэ тохиолдлууд бүртгэгдэх болжээ. КӨ нь зүрхний титэм судсыг гэмтээх аюултай ба өндөр хөгжилтэй орнуудын хүүхдийн зүрх судасны олдмол гажгийн тэргүүлэх шалтгаан болоод байна.

КӨ нь өндөр халуурах, уруул ба амны хөндийн салст улайх, мөчдөд өөрчлөлт гарах, арьсан дээгүүр янз бүрийн хэлбэр бүхий тууралт гарах, тунгалагийн булчирхай томрох шинжүүдээр илэрдэг. Эрт үед нь оношлож, тохирсон эмчилгээг хийгээгүйн улмаас өвчлөгсдийн 20-25% нь зүрхний титэм судасны цүлхэн, өргөсөлөөр хүндэрч, улмаар зүрхний шигдээс, цус тасалдал өвчнөөр нас барахад хүрдэг.

Нийт өвчтэй хүмүүсийн 85% нь 5 хүртэлх насны хүүхдүүд байдаг ба өвөл, хаврын цагт өвчлөл оргил үедээ хүрдэг ажээ. КӨ-ний тохиолдол Америк, Европ, Ази тивийн 60 гаруй оронд бүртгэгдэж, 10 гаруй оронд энэ өвчний дэгдэлт гарсан. Өнөө үед дэлхийд жил бүр 100,000 хүн амд 3,4-186,0 шинэ тохиолдол бүртгэгдэж байна.

Манай хөрш зэргэлдээ улсууд болох Оросын Холбооны Улсад 100,000 хүн амд 18,2, Хятад улсад 30,2 КӨ-ний шинэ тохиолдол гарч байна.

Гэтэл манай улсын хувьд өнөөг хүртэл КӨ-ний талаар мэдээлэл байхгүй, энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй бөгөөд КӨ-ний талаарх эмч нарын мэдлэг хангалтгүй байгаагаас буруу оношлох, тохирсон эмчилгээ хийгдэхгүй байх, улмаар өвчин хүндрэх, нас баралтанд хүргэх зэрэг асуудлууд тулгамдаж байна.

Зорилго: Улсын хэмжээнд Монгол хүүхдийн дундах КӨ-ний тохиолдлыг илрүүлэн судлах.

Материал, арга зүй: Бид судалгаандаа Монгол улсын 21 аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн Эрүүл Мэндийн Нэгдэл, ЭНЭШТ-ийн зүрх судас, хүүхдийн тасгууд, ХӨСҮТ-ийн амьсгалын замын халдварын тасгуудад 1996-2008 оны хооронд хэвтэж эмчлэгдсэн 0-16 настай 241705 хүүхдүүдийн өвчний түүхэнд эргэмж судалгааг хийж, Японы Кавасакийн Өвчин Судлалын Төвөөс боловсруулсан Кавасакийн өвчний оношлогооны удирдамжийг ашиглан КӨ-ний тохиолдлыг илрүүллээ.

Үр дүн: Нийт 241705 өвчтний түүхэнд судалгаа хийж, Кавасакийн өвчний 9 тохиолдлыг илрүүлсэн ба КӨ-тэй хүүхдүүдийн насыг авч үзэхэд 1 нас 4 сартайгаас 14 насны хооронд хэлбэлзэж, дийлэнх нь (77,8%) нь эрэгтэй хүүхдүүд байлаа. КӨ-ний 6 (67%) тохиолдолд үндсэн 6 шинжүүд бүгд илэрсэн ба бусад тохиолдлуудад 4 ба 5 шинжүүд илэрчээ. Халуурах, нүдний салст улайх, уруул амны хөндийд өөрчлөлт гарах шинжүүд нь хамгийн элбэг тохиолдож байсан бол хүзүүний тунгалгийн булчирхай томрох шинж нь харьцангуй цөөн илэрсэн байв. Зүрхний эхокардиографийн шинжилгээ хийлгэсэн 5 хүүхдэд бүгд зүрхний талаас хүндрэл гарч, зүрхний титэм судасны өргөсөл, цүлхэн үүссэн байна.

Дүгнэлт: КӨ-ний тохиолдлыг илрүүлэх үндэсний судалгаагаар КӨ-тэй хүүхэд Монгол Улсад байдаг болох нь тогтоогдоо. Иймд цаашид КӨ-ний үндэсний судалгааг үргэлжлүүлж, тохиолдлуудыг бүртгэж мэдээлдэг, шалтгааныг нь тогтоох шаардлагатай байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэгийг үнэлсэн судалгаа

Ж. Баярсайхан¹, Ч. Бямбасүрэн², Д.Өлзиймаа¹

¹Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв,

²Улсын Клиникийн Төв Эмнэлэг

Өсвөр үеийнхний “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн талаарх мэдлэг хандлагыг тогтоох, гэр бүл төлөвлөлт болон, бэлгий харьцаа, жирэмслэлтээс сэргийлэх аргын мэдлэг тогтоох зорилгоор олон улсын болон Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн, өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэгдсэн төслийн үр дүнг төсөл хэрэгжсэн болон төсөл хэрэгжээгүй газрын хүүхдүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг хандлагын түвшинг тогтоох замаар үнэлэв. Уг судалгааг системчилсэн түүврийн аргаар ХУД-ын ерөнхий боловсролын сургуулиудын НҮЭМ-н төсөлд хамрагдсан болон төсөлд хамрагдаагүй 15, 52, 7-р сургуулийн нийт 102 хүүхдээс системчилсэн түүврийн аргаар судалгааг авч, цуглуулсан мэдээ баримтаа Microsoft Excel, Microsoft Word программуудыг ашиглан боловсруулалт хийв.

Судалгааны ажлын таамаглал

Н0: НҮЭМ-ийн төсөл сургалтанд хамрагдсан эсэхээс үл хамаарч судалгаанд хамрагдсан ХУД-ийн арван нэгэн жилийн гурван сургуулийн 14-17 насны сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин ижил байна.

Н1: НҮЭМ-н төсөл сургалтанд хамрагдсан сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин сургалтанд хамрагдаагүй хүүхдүүдээс ялгаатай байна.

Үрдүн: НҮЭМ-тэй холбоотой мэдээлэл хангалтгүй гэж төсөлд хамрагдсан сурагчдын 38.1%, төсөлд хамрагдаагүй сурагчдын 26.6% нь тус тус үзэж, тэдний 11.5% нь илүү ихээр мэдээлэл шаардлагатай байна гэж хариулжээ. Төсөлд хамрагдсан сурагчдын 56.3% нь хамрагдаагүй сурагчдын 65.9% нь хэвлэлээс мэдээллээ олж авдаг гэсэн бол НҮЭМ-ийн талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцаагүй гэж төсөлд хамрагдсан сурагчдын 53.7% нь төсөлд хамрагдаагүй сурагчдын 55.5% нь тус тус хариулсан нь төсөлд хамрагдсан сурагчдын 1.8% нь гэр бүлийнхэнтэйгээ бага ярилцдаг ажээ. БЗХӨ-ний талаар зохих хэмжээний ойлголттой гэж төсөлд хамрагдсан сурагчдын 87.5% нь, хамрагдаагүй сурагчдын 75% нь хариулсан нь төсөлд хамрагдсан сургагчдын мэдлэг хамрагдаагүй сурагчдаас 12.5%-иар илүү байгааг харуулж байна. БЗХӨ авсан байж болзошгүй гэж үзвэл хамгийн түрүүнд эмнэлэгт хандана гэж төсөлд хамрагдсан сургуулын сурагчдын 38.1% нь төсөлд хамрагдаагүй сургуулын сурагчдын 35.1% нь эмнэлэгт хандана гэж хариулсан нь төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургуулийн сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэг хандлага ялгаатай байгааг харуулж байна.

Дүгнэлт: Н1 таамаглал буюу НҮЭМ-н төсөл сургалтанд хамрагдсан сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин сургалтанд хамрагдаагүй хүүхдүүдээс ялгаатай байна.

HBsAg илэрсэн Монгол хүүхдүүдийн цочмог А вирусийн халдварын эмнэлзүйн онцлог

Ж.Улаан¹, Я.Давгадорж², Д. Чимэдноров¹, Б.Батсүх¹

¹Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв,

²Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

Монгол улсад В вирус хепатит нь нутагшмал халдвар. Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 1991 оноос В вирус хепатитын вакцинаар шинээр төрсөн хүүхдүүдийг дархлаажуулж эхэлсний дүнд цочмог вирус хепатитын өвчлөл, элэгний дутагдлын улмаас нас барах нь эрс буурсан. Гэвч практикт цочмог А болон В вирус хепатитын хавсарсан хэлбэрийн өвчлөл бүрэн зогсоогүй байна.

Зорилго: HBsAg илэрсэн хүүхдүүдэд цочмог А вирусийн халдварын эмнэлзүйг судлах

Үрдүн: 1-р бүлгийн хүүхдүүдэд хүнд хэлбэр 7.8%, хүндэвтэр хэлбэр 23,5%, 2-р бүлэгт хүнд хэлбэр 50%,